## Гарчиг

**1. Төслийн товч танилцуулга**......................................................................3

1.1 Төслийн уулын ажлын төлөвлөгөө товч танилцуулга.......................................4

1.2 Төслийн зорилго.......................................................................................5

1.3 Төсөл хэрэгжиж буй газар засаг захиргаа..........................................................5

1.4 Төсөл хэрэгжүүлэгч.......................................................................................5

1.5 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг...................................................................6

1.6 Төсөл хэрэгжиж буй байршил................................................................7

2 Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт..........................................8

**3** Нөхөн сэргээлийн төлөвлөгөөний биелэлт ..................................................18

**4** Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт..........................................21

**5** Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний биелэлт..........................................23

**6** Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт..................................23

**7** Химийн бодис эрсдлийн менжементийн төлөвлөгөөний биелэлт ........................23

**8** Осол эрсдлийн бууруулах менжементийн төлөвлөгөөний биелэлт......................23

**9** Хог хаягдлын менжементийн төлөвлөгөөний биелэлт..........................................27

**10** Орчины хяналт-шинжилгээний хөтөлбөр..............................................................30

**11** Удирдлага зохион байгуулалт менжементийн төлөвлөгөөний биелэлт...............32

**12** Тухайн жилийн байгаль орчиныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин оршин суугчдад тайлагнах хуваарийн биелэлт .........................33

13 БОМТ нийт зардал.........................................................................................34

## Оршил

“Цагаанчулуутын” аман дахь талбайд 1913 оноос 1918 он хүртэл хувь нийлүүлсэн Монголор нийгэмлэг, 1943-1956 онуудад Монголын уул уурхайн алба ашиглалт явуулж байсан. Энэ ордын зураглал эрэл хайгуулын ажлыг 1950-1970 онуудад хийж байсан ба 1982 онд Монгол-Германы хамтарсан геологийн экспедиц нөөцийн судалгаа хийж, тайлан гаргасан байна. 2000-2012 онуудад далд аргаар ашиглан батлагдсан нөөцийг бүрэн олборлож дуусгасан. 2012-2013 онуудад нэмэлт хайгуулын ажил хийж хайгуулын ажлын үр дүнг 2019 онд 89 мян.тн хүдэр 105.21 кг алны нөөцийг ЭБМЗ-өөр батлуулан бүртгүүлсэн.

Нөөцийг байгаль орчинд хор нөлөөлөл багатайгаар алтны үндсэн ордыг бүрэн ашиглах багана болон гарш хэсгийн цулд үлдсэн нөөцийг ил аргаар олборлон авах зорилгоор 2018 онд Балчулуу ХХК-иар ТЭЗҮ-г хийлгэн батлуулсан.

2019-2020 онд далд аргаар ашиглах явцад хаягдсан ашиглалтын хаягдал буюу хамгаалалтын багана, карьерийн цулд үлдсэн хаягдлыг ил аргаар олборлон дуусгасан.

2019 онд батлагдсан нөөцөд үндэслэн ордыг далд аргаар ашиглах ТЭЗҮ-г “Грийн Вишн” ХХК гүйцэтгүүлэн батлуулсан бөгөөд 2021-2024 онд далд аргаар олборлолтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 19-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу боловсоруулав.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

“Цагаанчулуутын” 1817А тоот 25 гектар хэмжээтэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь (Зураг №1) Улаанбаатар хотоос хойш 135км, төмөр замын Баруун хараа өртөөнөөс (Баянгол сум) зүүн урагш 28км зайд оршдог. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол (Зураг №2)

| | |
|---|---|
| 1. 106° 12′ 9.2″ | 48° 42′ 25.87″ |
| 2. 106° 12′ 9.2″ | 48° 42′ 1.88″ |
| 3. 106° 11′ 39.2″ | 48° 42′ 1.88″ |
| 4. 106° 11′ 39.2″ | 48° 41′ 44.86″ |

Ордын талбай нь Хойд Хэнтийн төвийн өргөрөгийн уулархаг мужид оршдог. Рельефийн хувьд хөндий, хоолойгоор тусгаарлагдсан 900-1500м өндөрлөг газар байрлана.

**Цаг уур**

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай, хуурайдуу сэрүүвтэр болон чийглэгдүү сэрүүн мужийн нэн хүйтэн дэд муж бүхий зааг нутагт оршино. Жилийн дундаж агаарын температур -1.0°С, нийлбэр хур тунадас 308мм, үүний 90% нь 5-9 сард унадаг. Жилд бороотой өдрийн тоо 50-аас дээш, цас орох өдрийн тоо 20-30 хоног тус тус байна. Хамгийн хүйтэн нь 1-р сард -40ч-46°С, хамгийн халуун нь 7, 8-р сарuудад +36ч38°С хүрдэг. Салхины жилийн дундаж хурд 2.4м/сек, хамгийн их хурд хавар 14-24м/сек. Уурхайн орчинд 5-6м/сек хурдтай салхилдаг.

**Дэд бүтэц**

Дэд бүтцийн хувьд эрчимтэй хөгжиж байгаа төвийн бүст хамаарна. Тус орд нь Улаанбаатар-Сүхбаатарын хатуу хучилттай замаас зүүн зүгт 3км зайд байрладаг. Уурхайгаас зүүн хойш 8км зайд “Бороо гоулд” компаний алтны үйлдвэртэй. Үндсэндээ 25-90км радиус дотор сумын төвүүд, үйлдвэрийн төвлөрсөн газруудтай, асьфалтан болон төмөр замтай. Бүх төрлийн үүрэн телефоны холбоотой, интернет сүлжээнд бүрэн холбогдсон, байнгын ажиллагаатай зочид буудал, дэлгүүр ба ахуйн үйлчилгээний цэг, салбарууд бий. Ордын ойр орчим газар тариалан, мал аж ахуй маш сайн хөгжсөн.

## 1.1 **УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Сонортрейд” ХХК нь Цагаанчулуутын алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхээр 2020 онд “Грийн Вишн” ХХК-иар жилийн 24мян.тн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадалтай байх үеийн ТЭЗҮ-г боловсруулсан. Энэ онд **В-1, В-2, С-3, С-8, С-9-р** блокуудад олборлолт явуулсан.

Энэ онд нийт 13140 тн хүдэр олборлож 12.79кг химийн цэвэр алт боловсруулан баяжуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 11992 тн хүдэр боловсруулав.

Уулын ажил 4-р сарын 02 нд, үйлдвэрийн үйл ажиллагаа 4 –р сарын 6-аас эхлэн 2 ээлжээр 16 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

Төслийн нийт хамрах хүрээ нь “Сонортрейд” ХХК-ний эзэмшлийн 25га талбайтай Цагаанчулуутын алтны үндсэн ордын батлагдсан хүдрийн нөөцийг олборлох боловсруулах ажлуудаар хязгаарлагдана.

## **УУЛЫН АЖЛЫН ТЕХНИК,ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

“Цагаанчулуутын” алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах Техник эдийн засгийн үндэслэлд тусгасан техник, тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаандаа ашигласан. Үүнд :
Комбайн -1ш, 1тн даацтай өөрөө буулгагч 4ш, LIUGONG маркын дугуйт ачигч-1ш, YT-28маркын өрөм-2ш, хийн компрейссор-2ш, түлш түгээлтийн запрушка-1ш, HYUNDAI 2800 экскаватор 1ш, HOWO өөрөө буулгагч 1ш тус тус техникийн хүчин чадалтай ажиллаж байна.



Зураг 1 Hyundai 2800 экскаватор




Зураг 2 Хово өөрөө буулгагч



Зураг 3 LIUGONG маркын дугуйт ачигч



Зураг 4 Запрушка



Зураг 5 бага оврын өөрөө буулгагч

**1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО**

**“Сонортрейд”** ХХК нь ордыг бүрэн дүүрэн ашиглах зорилгоор 2019 онд батлагдсан нөөцийг далд аргаар олборлож ордыг хаягдалгүй байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглан эдийн засгын эргэлтэд оруулахад оршино.

**1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЗАСАГ, ЗАХИРГАА.**

**“Сонортрейд”** ХХК-ний Цагаанчулуутын алтны үндсэн орд нь Засаг захиргааны харъялалаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын гонир багын нутагт багтдаг.

**1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ.**

**“Сонортрейд”** ХХК, Улсын бүртгэлийн дугаар: № 9011196033, регистр 2590565

## 1.5 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ.

**Хүснэгт 1**

| **Аж ахуй нэгжийн нэр** | | **“СОНОР ТРЕЙД” ХХК** |
|---|---|---|
| **Аж ахуй нэгжийн хаяг** | Аймаг хот | Улаанбаатар |
| | Сум, Дүүрэг | Сүхбаатар |
| | Баг, Хороо | 8-р хороо |
| | Гудамж, Байр | Залуучуудын өргөн чөлөө |
| | Шуудангийн хайрцаг | ШХ-14 |
| | Утас | 311029 |
| | Факс | 976-11-323424 |
| | Гар утас | 99214188 |
| | Электрон шуудан | sonortrade@yahoo.com |
| **Захиралын хаяг** | Овог/Нэр | Б. Энхболд |
| | Утас | 311029 |
| | Факс | 976-11-323424 |
| | Гар утас | 99115698 |
| | Электрон шуудан | sonortrade@yahoo.com |

## 1.6 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙРШИЛ

Орд нь Улаанбаатар хотоос хойд зүгт 135км, Баруунхараа төмөр замын өртөөнөөс /Баянгол сум / зүүн урагш 28 км Улаанбаатар- Сүхбаатарын хатуу хучилттай замаас зүүн зүгт 3км зайд оршино. Орд нь Бороогийн нууранд орших алтны үндсэн бүлэг ордын зүүн хэсэгт байрлана.






- Цагаанчулуутын алтны үндсэн орд

**“Цагаанчулуутын “ алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийн талбайн байршил**



**Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** **Хүснэгт№-2**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **1.** | **Агаарын чанар** | | | | | | | | |
| 1.1 | Үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч хүний эрүүл мэнд болон орчны харагдах байдал мал аж ахуйн бэлчээрт салхиар дамжин сөргөөр нөлөөлөх | Далд уурхай 53 хоног ажилласан ба орчны тоосжилт харьцангуй бага буюу чийгшлт 10% орчим байсан тул уурхайн орчинд тоосжилт үүсээгүй | 25га | хоног | 0 | 0 | 0 | 0 | “Агаар орчны чанарын үзүүлэлт”.<br>-Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2011-10-10-ны өдрийн А-342 дугаар тушаалаар баталсан<br>-“Агаарын тухай” хууль, 2012 он<br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 05 сарын 15-ны өдрийн А/160 тоот тушаалын дагуу ажилласан ажлын хэсгийн зөвлөмж |
| 1.2 | Техникийн утаа стандартаас ихэсч агаар бохирдуулах | Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагтай тоног төхөөрөмжүүд нь цахилгаан эх үүсгүүрээр ажилладаг бөгөөд хэрэглэж буй дотоод шаталтат хөдөлгүүртэй 2 техникт 1 удаа үйлчилгээ хийгдсэн. | 2.5га | Жил | 260 | 2 | 520 | 1 | |
| 1.3 | Шатах тослох материал уурших | Шатах тослох материалыг битүүмж сайтай саванд хадгалж ууршихаас сэргийлэхээс гадна 3тн-ы түлш түгээлтийн машин ашиглав. | 0.03га | Сард | 0 | 0 | 0 | 3 | |
| 1.4 | Цагаан тоос босох том ширхэгтэй тоосонор дэгдэх | Хаягдлын санг чийгтэй элсээр хучих ажлыг 20 хоногт 1 удаа хийсэн. Энэ нь хаягдлын сангийн овоолгыг өндөрлөх 1 дамжлага юм. | 0.8га | Сард | Энэ зардал нь үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | | 1 | |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **2.** | **Гадаргын ба газрын доорхи усны нөөц** | | | | | | | | |
| 2.1 | Түлш шатахуун, шатах тослох материал, ахуйн бохир ус асгарч алдагдах тохиолдолд бага гүнд орших уст давхаргын усыг бохирдуулах | Үйлчилгээ тосолгоо хийхдээ засварын талбайд асгаралтын хувин хэрэглэн асгаралтаас сэргийлсэн зориулалтын түгээх хошуу бүхий 3тн-ы түлш түгээлтийн машин ашиглав. | 0.03га | Сард | 0 | 0 | 0 | 3 | Усны тухай" хууль, 2012 он;<br>-"Ус бохирдуулсны төлбөрийн тухай" хууль, 2012 он;<br>-MNS 0900:2010 "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ"<br>-MNS 4943:2011 |
| 2.2 | Нэгэн зэрэг бөөнөөр тэсэлсэний улмаас их хэмжээний ан, цав үүсч гүний усны эко-систем эвдэх | Газрын гүнд ӨТА хийхдээ тэсэлгээний ажил хийх паспортын дагуу нэг хоромд тэсрэх тэсрэх бодисын хэмжээ 1.2-оос 4.8кг байхаар гүйцэтгэв. | 0.8га | Хоногт | 0 | 0 | 0 | 2 | |
| 2.3 | Бохир ус | Бохир усны дүгнэлт гаргуулсан | 0.03га | Жилд | 0 | 0 | 0 | 1 | |
| | Уст цэгүүдийн мэдээлэл цуглуулах | Мониторингийн цэгүүдээс авсан дээжийн хариуг үндэслэн мэдээлэл цуглуулж байна. | 25га | Жилд | 0 | 0 | 0 | 2 | |
| **3.** | **Хөрсөн бүрхэвч** | | | | | | | | |
| 3.1 | Техник хэрэгсэл эвдэрж тос масло, гидрийн шингэн , түлш зэрэг асгарч хөрсийг бохирдуулах. | Тос масло асгарахаас сэргийлж асгаралтын сав хэрэглэдэг /25см диаметртэй 20 л багтаамжтай хуванцар сав/ | 25га | ш | 0 | 0 | 0 | Өдөр бүр | -"Газрын тухай" хууль, 2012 он;<br>"Газрын төлбөрийн тухай" хууль, 1997 он;<br>-MNS 3473:1993 "Газар ашиглалт. Нэр томъё, тодорхойлолт"; |
| 3.2 | Олон салаа зам гаргаснаар хөрсөн бүрхэвч эвдрэх. | Одоо байгаа технологийн замыг ашиглав. | 25га | Жил | 0 | 0 | 0 | Өдөр бүр | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Ил задгай хог хаяснаас үүдэх хөрсний бохирдол | - хог хаягдлын байгуулсан цэгт ангилан төвлрүүлж, халдваргүйжүүлэлт хийв | 25га | Жилд | 400 | 1 | 400 | Өдөр бүр | -MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт" |
| 3.4 | Тоосжилтын улмаас хөрсөн бүрхэвч эвдрэх | Далд уурхайгаас хийх тээвэрлэлтийн явцад тоосжилт бага байсан тул усалгаа хийгдээгүй. | 0.09га | Жилд | 0 | 0 | 0 | 0 | |
| 3.5 | Гал түймэр гарах | Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт 1 удаа зохион байгуулсан ба ажлын байрны галын дүгнэлт гаргуулж нэмэлтээр 2 байршилд галын хор байршуулсан | 25га | Жилд | 60 | 2 | 120 | 1 | |
| | **Нийт** | | | | | | **620** | | |
| **4.** | **Газрын хэвлий** | | | | | | | | |
| 4.1 | Далд уурхайн төлөвлөлт алдагдсанаас болж төлөвлөгдөөгүй л орон зай үүсэх. | Уулын ажлыг төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан. | 2га | Жилд | 0 | 0 | 0 | Тогтмол | Газрийн хэвлийн тухай хууль. Байгалийн ургамлын тухай" хууль, 1995 он; -"Ургамал хамгааллын тухай" хууль, 2007 он; -MNS 5918:2008 "Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага". |
| 4.2 | Газрийн гадаргад хэт ойр буюу цөмрөлт үүсэх. Хүн, мал, амьтан унаж бэртэх. | Дөрөвдөгчийн хурдасд ойр олборлолт хийгдээгүй | 2га | Жилд | 0 | 0 | 0 | Тогтмол | |
| 4.3 | Уурхайн нөлөөгөөр нуралт суулт үүсч хохирол учруулах | Нуралт, гулсалт, суулт зэрэг аюулаас сэргийлж аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэгжүүлж ажиллав. | 0.8га | Жилд | 0 | 0 | 0 | Тогтмол | |
| 4.4 | Нэгэн зэрэг бөөнөөр тэсэлсэний улмаас уулын даралтыг тогтоон барьж дийлээгүй мөн их хэмжээний ан, цав үүсгэх | Тэсэлгээний ажлыг паспортын дагуу хийж гүйцэтгэсэн | 0.8га | Жилд | 0 | 0 | 0 | Тогтмол | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **5.** | **Ургамлан нөмрөг** | | | | | | | | |
| 5.1 | Ашиглагдаж буй техник хэрэгслийн засвар үйлчилгээнээс гарч буй тос масло урсшиж тухайн орчны ургамалан бүрхүүл мал амьтанд сөргөөр нөлөөлөх. | Аюултай хог хаягдлын цэгт зориулалтын тагтай саванд хадгалж цуглуулан бүртгэж аюултай хог хаягдлыг боловсруулах албан ёсны эрх бүхий байгууллагад тушаав. | 25га | Жилд | 0 | 0 | 0 | 1 | -Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж -Байгалийн ургамалын тухай хууль 1995 он -Ургамал хамгаалах тухай хууль 2007 он |
| 5.2 | Дур мэдэн зам гаргах | Олон салаа зам гарахаас сэргийлж сургалт зохион байгуулав. | 25га | Жилд | 0 | 0 | 0 | 2 | |
| 5.3 | Гал түймэр гарах | Галын 2ширхэг хор байршуулав галын сараа засч сайжлуулсан | 25га | Жилд | 0 | 0 | 0 | 1 | |
| 5.4 | Шимт хөрс хуулж ургамалын нөмрөг сүйтгэх | Уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажилласан ба энэ онд шимт хөрс хуулаагүй | 25га | Жилд | 0 | 0 | 0 | Тогтмол | |
| **6.** | **Амьтны аймаг** | | | | | | | | |
| 6.1 | Үйл ажиллагааны явцад тухайн талбайн шавьж, жижиг мэрэгчид зэрэг амьтад үгүй болох | Ажглалтын 1 цэг байгуулсан | 25га | Ш | 0 | 0 | 0 | | - Ан амьтны тухай хууль 2012 |
| 6.2 | Их дуу чимээнээс болж амьтад даажих | Далд уурхайн тэсэлгээ нь 1-р амнаас 50м-ээс гүнд хийгдэж байсан тул дуу чимээ бага гарсан. Үйлдвэрт шинээр тоног төхөөрөмж суурилуулаагүй тул дууны давтамж 85дб-ээс хэтрээгүй | 25га | Жилд | 0 | 0 | 0 | | |
| 6.3 | Хүний буруутай үйл ажллагаанаас болж дүрвэх. | Ажилчдыг хүрээлэн буй орчинтой зүй зохистой харицах талаар сургалт явуулж ажилд ирэх очих маршрутаас өөрөөр | 25га | Жилд | 0 | 1 | 1 | жилд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвшөөрөлгүй зорчихыг хориглодог болсон | | | | | | | |
| **Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал** | | | | | | | **1140** | | |

**Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлтийн ажлын үйл явц**



**Зураг№-7** Үйлдвэрээс гарсан хаягдал элс нь чиигшлийн хувьд 15% хүртэл чийгшилтэй байгаа болович өнгөн хэсэгтээ өөрийн чиигийг алдаж хуурайшин цагаан тоос босох нөхцлийг бүрдүүлдэг учир эргэлтийн нуурыг цэвэрлэх үедээ 1-2м зузаан чиигтэй элсээр хучих ажлыг хийдэг. Энэ нь хаягдалын даланд байх овоолгийг өндөрлөхөд ач холбогдолтой тул ийнхүү хийж гүйцэтгэж байна.



**Зураг№-8** Олборлосон хүдрийг шигшиж 2 фракц болгон ангилах нь бутлагдах хүдрийн хэмжээг багасгах сайн талтайгаас гадна ыутлах үед үүсэх тоосжилтыг багасгах сайн талтай.





**Зураг№-9** Бутлах хүдрийн талбай

**Зураг№- 10**Анхдагч хүдрийн талбай





**Зураг №-11** Бутлагдсан хүдэр

**Зураг №-12 Нөөцийн талбай**




**Зураг №- 13** Ажилчдын хувцас, усанд орох, гар нүүр угаах зэрэг ахуйн хэрэглээнээс гарч буй саарал усыг хөрсөөр нэвчүүлэн цэвэрлэх аргыг ашигладаг. Бөгөөд 10тн багтаамжтай чайн суурилуулан лагыг тунгаан орчины хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажилласан.



**Зураг №-14** Түлш түгээх зориулалтын машин хэрэглэсэнээр түлш асгарах ууршиx зэрэг хөрсөнд шууд үзүүлэх сөрөг нөлөөлөл багассан.



**Зураг №-15** Далд уурхайгаас олборлосон хүдрийг 30тн –ын даацтай өөрөө буулгагчаар 0.4км технологийн замаар зөөвөрлөн анхдагч хүдэр хүлээн авах талбайд хүргэнэ. Энэхүү тээвэрлэлт нь хоногт 2-4-н удаа хийгдэх тул тоосжилт эрс багассан.



**Зураг №- 16** 50мм –ийн хөндлөн огтлол бүхий цагаан PVC хоолойгоор газрын гүний усыг соруулан шахаж эргэлийн нуурт төвлрүүлэн хэрэглэдэг.



**Зураг №-17** Уурхайгаас олборлосон хүдрийг 2тн даацтай өөрөө буулгагчаар далд уурхайн ам буюу ил уурхайн ёроолд байх хүдэр буулгах талбайд нөөцөлнө.

Уг талбайд 80-120тн хүдэр нөөцлөгдмөгц уурхайн хүдэр хүлээн авах талбай руу ачуулна.



**Зураг №-18** Ил уурхайг тойруулан үерийн далан татаж гар болзошгүй үер усны болон хүн-мал, амьтан унаж бэртэхээс сэргийсэн байдаг.













**Зураг №-19** Уурхайн бүсэд байршуулсан тэмдэг тэмдэглэгээ

## 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Сонор трейд ХХК-ний Цагаанчулуутын далд уурхай нь 2018-2020 онд үүссэн ил уурхайн ёроол хэсэгээс үндсэн траншей нэвтрэн орж 2019 онд ЭБМЗ-өөр батлагдсан нөөцийг нээсэн тул ордын нөөц дуусч хаалтын төлөвлөгөөнд тусгагдан хийгдэх тул энэ онд нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй

Төслийн хүрээнд уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нийт талбай 13.178-аас 1.4га талбайд техникийн нөхөн сэргээлтийг 2020 онд хийж 2021онд биологийн нөхөн сэргээлтийг 1.2га тайлбайд хийснээр нөлөөлөлд өртсөн талбайн нийт хэмжээ 11.978га

**Хүснэгт -3**

**Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн талбай**

| № | Үйл ажиллагааны төрөл | | Талбайн хэмжээ /га/ |
|---|---|---|---|
| | **Ил уурхайн нөлөөлөлд өртсөн талбай** | | |
| 1 | 2019 онд олборлолтод өртсөн талбай | | 2.6 |
| 2 | 2020 онд олборлолтод өртсөн талбай | | 1.4 |
| 3 | Гадаад овоолго | | 4.9 |
| 4 | Технологийн зам | | 1.6 |
| 5 | Засвар, паркын талбай | | 0.2 |
| 6 | Хүдэр овоолгийн талбай | | 0.72 |
| 7 | Хаягдалын сангийн талбай | | 1.5 |
| 8 | Барилга байгууламжын талбай | | 0.168 |
| 9 | Тэсэлгээний агуулахын талбай | | 0.09 |
| | Бүгд | | 13.178 |
| | **Далд уурхайн нөлөөлөлд өртсөн талбай** | | |
| 1 | 2021 онд олборлолтод өртсөн талбай | | 0.24 |
| 2 | 2022 онд олборлолтод өртсөн талбай | | 0 |
| 3 | 2023 онд олборлолтод өртсөн талбай | | 0.26 |
| | 2024 онд олборлолтод өртсөн талбай | | 0.12 |
| 4 | Гадаад овоолго | | 0 |
| 5 | Технологийн зам | | 0 |
| 6 | Засвар, паркын талбай | | 0 |
| 7 | Хүдэр овоолгийн талбай | | 0 |
| 8 | Хаягдалын сангийн талбай | | 0 |
| 9 | Барилга байгууламжын талбай | | 0 |
| **10** | Тэсэлгээний агуулахын талбай | | 0 |
| | Бүгд | | 0.62 |

2019 онд батлагдсан ордыг далд аргаар ашиглах ТЭЗҮ-д далд уурхайн улмаас газрын хэвлийд үүсэх ил орон зайг хэвээр үлдээхээр тусгасны дагуу нөлөөлөлд өртсөн талбайн хэмжээнд нэмж тусгаагүй.

## 3.1 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Энэхүү хөдөлгөөний хүрээнд тарих модны тоог уурхай болон үйлдвэр байршиж буй байгалийн бүсчлэлийг харгалзан MNS5918:2008, байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлагын дагуу 412ширхэг мод уурхайн хашаанд тарив.

Зарцуулах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 07-р сарын 9-ны өдрийн А/172, 116 –рт “ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээний зардлын жишиг нормативыг шинээр болон шинчилэн батлах тухай” тушаалд зааснаар тооцов.

Хүснэгт №4

| № | Нэр/төрөл | Тоо/ширхэг | Нэгж бүрийн үнэ. мян.төг | Нийт үнэ мян.төг |
|---|---|---|---|---|
| 1 | Агч | 412 ш | 2500 | 1030 |
| 3 | Нийт | 412 | | |
| Тэрбум мод үндэсний хөдөлгөөний арга хэмжээний нийт зардал 1030 мян.төг | | | | |




**Зураг№-20** 2-3 настай агч мод шилжүүлэн суулгав /9-16/





**Зураг №-21** Уурхайн ёроол, далд уурхайн ам



**ураг №-26** Дотоод овоолгийн биологийн нөхөн сэргээлт одоогийн байдал /10-25



**Зураг №-22** Уурхайн одоогийн байдал /10-25/



**Зураг №-23** Гадаад овоолгийн одоогийн байдал /10-25/

## 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5-р хэсгийн 5.1.8 дахь заалт Уул уурхайн үйл ажиллагааны улимаас эвдэрч, олон жил орхигдсон 8мян\га талбайг нөхөн сэргээлт хийх зорилт болон дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хүний үйл ажиллагаагаар эвдэрч орхигдсон Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас 70км зайд байршилтай "Их өлөнт" нэртэй газарт 3га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэв.

Дүйцүүлэн хамгаалах нийт зардалд 17 сая төгрөг





**Зураг№-24** техникийн нөхөн сэргээлтийн өмнөх төрх байдал




**Зураг№-25** техникийн нөхөн сэргээлтийн үйл явц

**5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Цагаанчулуутын амны алтны үндсэн ордын орчимд буюу уурхайн орчимд төслийн нөлөөлөлд өртөж нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал гарахгүй учир “Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө” тусгайлан боловсруулах түүнийг хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

**6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө биелэлт**

Цагаанчулуутын уурхайн ашиглаж эхэлсэн үеэс өнөөг хүртлэх 10 гаруй жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд 2017 онд Археологи, Палентлогийн хүрээлэнгүүдээр талбайн хэмжээнд судалгаа хийлгэсэн.

Эдгээр судалгаат ажлын үр дүнгээр “Түүх, соёлын өв” илрээгүй / дүгнэлт хавсаргав/ 2023 оны уул ажлын явцад түүх соёлын зүйлс илэрээгүй болно

**7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө биелэлт**

Цагаанчулуутын уурхай нь баяжуулах, боловсруулах үйл ажиллагаандаа ямар нэг химийн бодис ашигладаггүй бөгөөд олборлолт хийхийн тулд үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх материал ашиглах ба гамшгаас хамгаалах эрсдлын үнэлгээг 2018 онд болон 2021 онд хийлгэсэн. Иймээс “Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй.

**8. Осол, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Цагаанчулуутын уурхайн алтны үндсэн ордыг далд аргаар хязгаарлагдмал орчинд ажиллаж буй талбайд анализ хийж эрсдлийг бууруулах арга хэмжээг ерөнхий инженерын удирдлага дор инженер техник, ХАБЭА-н ажилчид ажлын талбайд эрсдэлгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж зохион байгуулж ажлаа явуулсан. Уулын бүсэд ажиллаж буй ажилчидад ажилд гарахын өмнө ээлж ахлах мастер тухайн өдөр хийх ажлын наряд, ХАБЭА-н ажилтан аюулгүй ажиллагааны зааварчилгаа, эрсдлийн талаарх бодит мэдээлэлийг өгч анхааруулах тэмдэг орохыг хориглосон талбайд хил хязгаарыг зааглаж ажлын талбайд тухайн ээлжийн ахлах ажилтан хяналт тавьж эрсдэлгүй үйл ажиллагаа явуулж байна.

Гал түймэр гал гарах шалтгаан гал унтраах арга барилд ажилчдыг сургах дадлагыг 3-р улиралд онол, практик сургалтыг зохион байгуулав.

**Хүснэгт№-5**

| № | Болзошгүй аюул осол сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ | Хамрах цар хүрээ | Too хэмжээ | Нэгжийн зардал мян\төг | Нийт зардал мян\га | Давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Осол, эрсдлийн менежментын төлөвлөгөөний биелэлт** | | | | | | | | Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, 2012 он;<br>-“Галын аюулгүй байдлын тухай” хууль, 1995 он;<br>-“Галын аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, 2012 он;<br>-MNS 4244-94<br>Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” |
| 1 | Цахилгааны тоног төхөөрөмжөөс үүсэх гал түймэр гарах<br><br>Ажиллагсдын анхаарал, болгоожгүй байдалаас үүдэн гал түймэр гарах | ГАА даган мөрдөх ажилчид онол болон практик сургалтуудыг зохион байгуулсан.<br><br>Цахилгааны шитний хайрцагт анхааруулах санамж өлгөсөн. | Нийт ажилтан | 1 | 30 | 30 | 1 | |
| 2 | Даралтат савыг буруу ашигласанаас болж аюул осолд өртөх | Ахуйн газ алдах эрсдэл байна гэж үзэн мэргэжлийн компаниар ахуйн газны холболт угсралтыг хийлгэж хий алдадтын үед автоматаар хаах тоноглол суурилуулсан | Нийт ажилтан | 1 | 1540 | 1540 | 1 | |
| 3 | Аянга цахилгаан, аадар бороо, хүчтэй салхи, шуурганы улмаас аюул, осолд өртөх; | Ажилчдад аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө болох гамшгийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг танилцуулан гарч болох эрсдэлийг таниулсан | Нийт ажилтан | 0 | 0 | 0 | 1 | |
| 4 | Хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг зөрчсөнөөс үйлдвэрлэлийн осолд өртөх. | Нийт ажилчдад өдөр тутмын болон уридчилсан заавчилгаагаар хангах, хийж гүйцэтгэх ажлын нөхцөлд тохируулан ХХ хувцас, ХХХэрэгслэр хангах ажлууд хийгдэв. | Нийт ажилтан | 16 | 210 | 3360 | 1 | |
| Осол, эрсдлийн менежментын төлөвлөгөөний нийт зардал | | | | | **4930 мян\төг** | | | |

**Уурхайд ажиллаж буй ажилчдад ХАБЭА-н сургалт орж буй ажлын үйл явц**



**Зураг№-26** ХАБЭА-н сургалт



**Зураг№-27** Галын аюулгүй байдлын практик сургалт



**Зураг№-28** Галын аюулгүй байдлын практик сургалт



Энэхүү автомат таславч нь ахуйн газ алдалтын үед хийн шугмыг цаг алдалгүй хааж дахин газ алдахаас сэргийлдэг бөгөөд энэхүү үүргээ газ мэдрэх цахилгаан хошууны тусламжтай гүйцэтгэдэгээс гадна хий алдалт байсаар байвал шугам нээгдэх үйлдэл хийгдджггүй сайн талтай.

**Зураг№-29** газ мэдрэгч, таславч

## 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагаа явагдаж буйтай холбогдуулан үйлдвэрлэлийн явцад гарч буй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайн бүсэд 3 төрөлд ялган ангилав.

a. **Ахуйн хог хаягдал**

- Энгийн хог хаягдал\ ажилчидын байранд цэвэрлэгээ хийх болон ахуйн хэрэглээнээс гарч буй хог хаягдлыг 6:3м харьцаатай зуфенд цуглуулсан бөгөөд уурхайн үйл ажиллагаа зогсохын өмнө Сэлэнгэ аймгийн Баянгол сумын хогийн цэгт төвлөрүүлж хаяна.

b. 2догч хог хаягдал \ахуйн хэрэглээнээс гарсан хуванцар сав, цаас зэргийг ялган 2:1.5м харьцаатай хашаанд цуглуулав.

c. **Ахуйн шингэн хог хаягдал**:

Ажиллагсдын хоолыг үйлдвэрлэх явцад гарч буй шингэн хог хаягдлыг 3:2.5 $м^2$ харьцаатай зумфэнд цуглуулдаг. Ажиллагсад усанд орох, хувцас угаах,нүүр гар угаах үед ашиглагдсан бохир усыг 3:4 харьцаатэй зумфэнд цуглуулдаг байсан бөгөөд 2021онд 10тн багтаамжтай чайныг суурилуулан лагыг тунгаан авч саарал усыг хөрсөнд нэвчүүлэх аргыг ашиглан зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

d. **Аюултай хог хаягдал:**

Байгальд удаан шингэдэг бөгөөдууршилт явагдаж агаарт дэгдэн хүний эрүүл мэнд болон ургамалан бүрхүүлд сөргөөр нөлөөлөх хог хаягдалыг аюултай хог хаягдал гэнэ. Аюултай хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулж бүртгэж дахин боловсруулагдах хог хаягдлыг 2-р дахь түүхий эд боловсруулах цэгт тушаана. Машин техникийн засвар үйлчилгээг засварын талбайд хийж хөрсний бохирдол болон асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажилласан. Машин техникт үйлчилгээ хийхдээ тос, маслыг хуванцар саванд тосож авч аюултай хог хаягдлыг цэгт тушаах ажлыг техникийн операторуудад заавар өгч хэвшүүлж сургасан.

**Хүснэгт№-6**

| № | Хог хаягдлын ангилал | Арга хэмжээ | Хамрах хүрээ | Нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал мян\төг | Хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Б. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт** | | | | | | | | -“Хог хаягдлын тухай” хууль, 2012 он; -MNS 5924:2008 “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага”; - MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага” (нүхэн жорлон, угаадасны нүх байгуулахад ашиглах материалыг сонгохдоо уг стандартыг мөрдөнө); -MNS 4943-2011 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. |
| 1 | Ахуйн хаягдал | Зориулалтын цэгт | Хатуу | тн | 11 | 280 | сар | |
| | | | Бохир ус | $м^3$ | 86 | 0 | сар | |
| | | | Хаягдал яс | тн | 0.2 | 0 | Сар | |
| | | | Үнс | тн | 1.4 | 0 | Сар | |
| | Хоёрдогч хаягдал | ангилах | Цаас, картон | кг | - | 0 | Сар | |
| | | ангилах | Шил сав | кг | - | 0 | Сар | |
| | | ангилах | Хуванцар | кг | 46 | 0 | Сар | |
| | | ангилах | лааз, сав | кг | - | 0 | Сар | |
| 2 | Үйлдвэрийн хаягдал | Зориулалтын цэгт | Хатуу хаягдал | тн | 6 | 0 | Сар | |
| 3 | Аюултай хаягдал | Зориулалтын цэгт | Ашигласан тос | л | 1350 | 300 | сар | |
| | | Зориулалтын цэгт | Шатах, тослох материалын сав | кг | 5 | 0 | Сар | |
| | | Зориулалтын цэгт | Аккумулятор | ш | 3 | 0 | сар | |
| | | Зориулалтын цэгт | Хуучин дугуй | ш | - | 0 | сар | |
| **Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт нийт** | | | | | | 580мян\төг | | |




**Зураг№-30** Ахуйн хог хаягдалын цэг




**Зураг№-31** Шингэн хог хаягдалын цэг




**Зураг№-32** Аюултай хог хаягдалын цэг

## 10. Орчины хяналт- шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжиж буй  талбайд ил аргаар хүдэр олборлох болон баяжуулах үйлдвэрт хүдэр боловсруулах үйл ажиллагааг явуулж байгаатай холбогдуулан  хөрс, ус, агаарын  шинжилгээг Сэлэнгэ аймгийн УЦУОХШГазарт 6, 9 -р сард, шинжилгээ хийлгэв.

**Хүснэгт№-7**

| № | Үзүүлэлт | Дээжний цэгийн байршил | Давтамж тоо\ширхэг\ | Нэгжийн зардал мян\төг | Нийт зардал мян\га | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|
